МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР

INFF
Integrated National Financing Frameworks

МОНГОЛ УЛСЫН ҮНДЭСНИЙ САНХҮҮЖИЛТИЙН НЭГДСЭН СТРАТЕГИ

Б.Дэлгэрмаа
НҮБ-ын Хөгжлийн Хөтөлбөрийн
Тогтвортой Санхүүжилтийн Зөвлөх

UNDP

unicef
for every child

UNITED NATIONS MONGOLIA

JOINT SDG FUND

Агуулга

1) **Монгол Улсын хөгжлийн бодлого, санхүүжилтийн хэрэгцээ**

2) **Олон улсын туршлага:**
   - Үндэсний санхүүжилтийн нэгдсэн тогтолцоо
   - Санхүүгийн боломж

3) **Монгол Улсын Үндэсний санхүүжилтийн нэгдсэн тогтолцоо**
   - ҮСНТ-г Монгол Улсад хэрэгжүүлэх хүрээнд хийгдэж буй ажлууд
   - Үндэсний санхүүжилтийн нэгдсэн стратеги

1) Монгол Улсын хөгжлийн бодлого, санхүүжилтийн хэрэгцээ

Монгол Улсын хөгжлийн бодлого, санхүүжилтийн хэрэгцээ

АЛСЫН ХАРАА - 2050

Монгол Улс “нийгмийн хөгжил, эдийн засгийн өсөлт, болон иргэдийн амьдралын чанар” -аар Азид тэргүүлэгч орнуудын нэг болох зорилт тавьсан ба энэхүү зорилтуудыг арав, арван жилийн үечлэлтэй зорилтот хөгжлийн хөтөлбөрүүдээр дамжуулан хэрэгжүүлэхээр төлөвлөсөн



“ШИНЭ СЭРГЭЛТИЙН БОДЛОГО” | 2021 - 2030

“Шинэ сэргэлтийн бодлого” нь хөгжлийн зорилтот хөтөлбөрийн эхнийх бөгөөд Ковид-19 цар тахлын дараах эдийн засгийг сэргээх, хөгжлийн сорилт бэрхшээлийг нэн даруй шийдвэрлэх, ингэснээр урт хугацааны хөгжлийн явцыг хурдасгах зорилготой юм

ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН ЗОРИЛГУУД - 2030

Алсын хараа–2050 хөтөлбөрийн эхний арван жилийн үечлэл буюу 2021-2030 оны зорилтууд нь даян дэлхийн Тогтвортой хөгжлийн зорилгууд 2030 хөтөлбөртэй хугацаа болон зорилтын хувьд нийцэж байна

“МОНГОЛ УЛСЫГ 2021-2025 ОНД ХӨГЖҮҮЛЭХ ЖИЛИЙН ҮНДСЭН ЧИГЛЭЛ“

Энэхүү дунд хугацааны төлөвлөлтийн баримт бичиг нь улс орон, бүс нутаг, салбарын хэмжээнд нөөц, чадавх, хөгжлийн зорилго, зорилт, үр дүнгийн уялдаа холбоог хангах, хөгжлийн бодлогын залгамж чанарыг хадгалахад чиглэсэн

Монгол Улсын хөгжлийн бодлого, санхүүжилтийн хэрэгцээ

Монгол Улсын хөгжлийн бодлого төлөвлөлт, түүнийг санхүүжүүлэх системийн зураглал

ТӨЛӨВЛӨЛТИЙН СИСТЕМ

Урт хугацаа (11+ жил)

- Алсын хараа 2050
- Хөгжлийн зорилтот хөтөлбөрүүд (10 жил)

Дунд хугацаа (5-10 жил)

- Хөгжлийн үндсэн чиглэл (5 жил)
- УБ үндсэн чиглэл /5/
- Аймаг үндсэн чиглэл /5/
- Салбарын хөгжлийн хөтөлбөр
- Сэдэвт хөгжлийн хөтөлбөр

Богино хугацаа (1-4 жил)

- ЗГҮАХ (4 жил)
- ОНҮАХ (4 жил)
- Жилийн төлөвлөгөө
- ОН Жилийн төлөвлөгөө

НЭМЭЛТ САНХҮҮЖИЛТИЙН ХЭРЭГЦЭЭ

ТХЗ 2030

126 их наяд төгрөг ~ ДНБ-ий 18%
(ТХЗ 17 зорилтууд)

САНХҮҮЖИЛТИЙН СИСТЕМ

Үндэсний санхүүжилтийн нэгдсэн стратеги

(санал болгож буй хувилбар)

- Улсын ХО-ын хөтөлбөр
- Дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэл (ДХТХМ)
- Өрийн удирдлагын стратеги
- Хувийн сектор ХО дэмжих бодлого/стратеги
- Дунд хугацааны төсөвлөлтийн хүрээ (ДХТХ)
- Тогтвортой санхүүжилтийн бодлого
- ОУ-ын санхүүжилт, хөгжлийн хамтын ажиллагааны бодлого/стратеги
- ТХХТ-ийг дэмжих стратеги
- Санхүүгийн систем ТХ-д чиглүүлэх стратеги
- Дунд хугацааны орлогын бодлого
- Санхүүжилтийн үр ашгийг нэмэгдүүлэх бусад санхүүгийн бус стратегиуд (стандарт, арга хэрэгсэл)

- Улсын төсөв
- Орон нутгийн төсөв

Монгол Улсын хөгжлийн бодлого, санхүүжилтийн хэрэгцээ



37.4% 11.5% 9% 8.7% 8.6% 6.6%

2030 он хүртэл **ТХЗ-уудыг биелүүлэхэд** нийт **126 ИХ НАЯД** төгрөгийн нэмэлт зардал шаардлагатай ба энэ нь жилд дунджаар **ДНБ-НИЙ 18%-ТАЙ ТЭНЦЭХ** хэмжээний нэмэлт зардал юм



2) Олон улсын туршлага:

Үндэсний санхүүжилтийн нэгдсэн тогтолцоо

Үндэсний санхүүжилтийн нэгдсэн тогтолцооны бүрэлдэхүүн

Хөгжлийн зорилтуудад хүрэхэд ҮСНТ хэрхэн туслах вэ?

Шаардлагатай нөөц
- *Санхүүгийн нөөц*
- *Институцийн чадавх болон хүний нөөц*

Хэрэгжүүлэх ажлууд
- *Тогтмол үнэлгээ оношилгоо*
- *Санхүүжилтийн стратеги, түүний хэрэгжилт*
- *Удирдлага зохицуулалт*

Хүрэх зорилтууд
- *Харилцан уялдаа бүхий санхүүгийн бодлогууд (төрийн, хувийн, макро)*
- *Хөгжлийн санхүүжилтийн илүү нэгдмэл тогтолцоо*

Гарах үр дүн
- *Санхүүжилтийн эх үүсвэр нэмэгдэнэ*
- *Одоо байгаа санхүүжилт, хөрөнгө оруулалт хөгжлийн тэргүүлэх чиглэлүүдэд илүү сайн чиглэнэ*
- *Санхүүжилтийн үр нөлөө нэмэгдэнэ*

Эцсийн нөлөөлөл
- *Үндэсний хөгжлийн зорилтууд болон Тогтвортой хөгжлийн зорилтуудад хүрнэ*

3) Монгол Улсын Үндэсний санхүүжилтийн нэгдсэн тогтолцоо

ҮСНТ-г Монгол Улсад хэрэгжүүлэх хүрээнд хийгдэж буй ажлууд

ҮСНТ-г өөр өөрсдийн улс орны онцлог нөхцөл байдал, сорилт бэрхшээлүүд, боломж бололцоо, санхүүжилтийн хэрэгцээндээ нийцүүлэн боловсруулах чиглэлээр нийт 80 гаруй орнууд ажиллаж буйн нэг нь Монгол Улс юм.

ҮСНТ-НЫ АЖЛЫН ХЭСЭГ

Сангийн сайдын 2021 оны 1-р сарын тушаалаар Сангийн дэд сайд ахалсан ажлын хэсгийн байгуулагдав. Бүрэлдэхүүнд:

- ЗГХЭГ
- Салбарын яамдууд
- ҮАГ, МБ, СЗХ, ЖҮХ
- Хувийн хэвшил, холбоодын төлөөлөл
- ОУ байгууллагуудын төлөөлөл

Ажлын хэсэг

СУУРЬ СУДАЛГАА БА ҮНЭЛГЭЭ

2018 Хөгжлийн санхүүжилтийн үнэлгээ

2018 MAPS

2021 ҮСНТ-ны суурь үнэлгээ

Нэмэлт үнэлгээ

- ТХЗ-ын зардлын тооцоо
- Бусад ОУ-ын санхүүгийн байгууллагуудын үнэлгээ, тайлангууд
- Одоо авч хэрэгжүүлж байгаа үйл ажиллагааны зураглал
- Олон талт уулзалт, зөвлөлдөөн

Суурь үнэлгээ

СТРАТЕГИ БОЛОВСРУУЛАЛТЫН АЖЛЫН ЯВЦ

- *Стратеги боловсруулалт*
- *Үндэсний Санхүүжилтийн Нэгдсэн Стратеги*
- *Үйл ажиллагааны төлөвлөгөө*
- *Стратегийг хэрэгжүүлэх элементүүд*
- *Хяналт-шинжилгээ, үнэлгээний механизм*
- *Удирдлага зохицуулалтын механизм*
- *Явцын хэрэгжилтийн хянах шалгуур үзүүлэлтүүд*

Стратеги боловсруулалт

ҮСНТ-г Монгол Улсад хэрэгжүүлэх хүрээнд хийгдэж буй ажлууд

Суурь судалгаа болон нэмэлт үнэлгээнүүдийн үр дүн, зөвлөмжүүдээс онцлох нь:

- Төсөв болон бодлогууд хоорондын уялдаа сул, төсвийн зардлын үр ашиг хангалтгүй байгаа тул төсвийн зардлыг илүү дунд хугацаагаар төлөвлөх, үндэсний хөгжлийн тэргүүлэх чиглэлүүдтэй уялдуулах
- Өрийн удирдлагын үр ашгийг нэмэгдүүлж тогтвортой хөгжилд чиглүүлэх, төсвийн болон өрийн удирдлагын шинэчлэлийг хийх замаар өрийн тогтвортой байдлыг хангах

  Төсвийн зохистой удирдлагыг хангах, орлогын урсгалыг тогтворжуулах зорилгоор баялагийн сан байгуулах
- Төсвийн орлогыг нэмэгдүүлэх зорилгоор байгаль орчны татварын шинэчлэл, орлогын тэгш бус байдлыг багасгах татваруудыг нэвтрүүлэх, татварын удирдлагыг боловсронгуй болгох замаар татварын бааз суурийг өргөтгөх
- Эдийн засгийн төрөлжилт, өсөлтийг дэмжих зорилгоор ЖДҮ-үүдэд тулгарч буй санхүүжилтийн бэрхшээлийг бууруулах, хөрөнгө оруулалтаар дэмжих болон эрх зүйн орчинг таатай болгох
- 2030 он гэхэд байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлттэй холбоотой зорилтуудыг хангахад нийт 11.5 тэрбум ам.доллар, 2025 он гэхэд биологийн олон янз байдлын үндэсний хөтөлбөрийг санхүүжүүлэхэд 700 сая ам.доллар тус тус шаардлагатай байгаа тул байгаль орчин, уур амьсгалын зорилтот санхүүжилтийн хэрэгцээг хангахад хувийн хэвшлийн оролцоог нэмэгдүүлэх
- Төрийн өмчит аж ахуйн нэгжүүдийн ашигт ажиллагааг нэмэгдүүлэх, засаглалын тогтолцоог сайжруулах, үйл ажиллагааг нь хөгжлийн бодлоготой уялдуулах
- Төр, хувийн хэвшлийн түншлэлийн эрх зүйн орчин, хамтран ажиллах механизмыг сайжруулах замаар хувийн хэвшлийн санхүүжилтийг ТХЗ болон үндэсний хөгжлийн тэргүүлэх чиглэлүүдтэй уялдуулах
- ЖДҮ-ийн 60%-аас доошгүй эмэгтэйчүүд эзэмшдэг боловч тэдгээрийн 70% нь санхүүжилт огт эсвэл хангалтгүй байдлаар авдаг, эмэгтэйчүүдийн ажил эрхлэлтийн түвшин 52%, дээд шатны удирдлагын зөвхөн 29% нь эмэгтэйчүүд байгаа тул хүртээмжтэй, тогтвортой өсөлтийг бий болгохын тулд жендэрийн тэгш байдлыг хангах

Үндэсний санхүүжилтийн нэгдсэн стратеги

Үндэсний санхүүжилтийн нэгдсэн стратеги ба зорилтууд

Үндэсний санхүүжилтийн нэгдсэн стратеги нь “Монгол Улсыг 2021-2025 он хүртэл хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”-ийн хэрэгжилтийг санхүүжүүлэхэд тулгарах сорилтуудыг даван туулах нэгдсэн болон олон талт стратегиудыг тодорхойлох, түүнд тавих хяналт-шинжилгээ ба үнэлгээ, засаглал болон зохицуулалтын механизмуудыг бэхжүүлнэ

ҮСНС-ийн зорилтуд

1. **ЭХ ҮҮСВЭР НЭМЭГДҮҮЛЭХ**
   Монгол Улсын тогтвортой хөгжлийн санхүүжилтийн эх үүсвэрийг нэмэгдүүлэх
2. **ЧИГЛҮҮЛЭХ**
   Санхүүжилтийн эх үүсвэрийг тогтвортой хөгжилд чиглүүлэх
3. **ҮР НӨЛӨӨ**
   Хөрөнгө оруулалтын эдийн засаг, нийгэм, байгаль орчинд үзүүлэх нөлөөг нэмэгдүүлэх

Үндэсний санхүүжилтийн нэгдсэн стратегийн хүрээ

САНХҮҮЖИЛТИЙН НЭГДСЭН СТРАТЕГИ (2022-2025)

ТӨСВИЙН САНХҮҮЖИЛТ

- *Төсвийн орлого*
- *Засгийн газрын зээл*
- *Төсвийн зардал*
- *Улсын хөрөнгө оруулалт*
- *Хууль бус санхүүгийн урсгал*
- *Олон улсын хөгжлийн хамтын ажиллагаа*

ХУВИЙН ХЭВШЛИЙН САНХҮҮЖИЛТ БОЛОН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ

- *Арилжааны зориулалттай хөрөнгө оруулалт*
- *Хувийн хөрөнгө оруулалт*
- *Нөлөөллийн хөрөнгө оруулалт*
- *Арилжааны бус зориулалттай мөнгөн гүйвуулга*
- *Сайн үйлсийн зориулалттай хандив*

МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН ОРЧИН НӨХЦӨЛ

Өрийн тогтвортой байдал
Макро эдийн засгийн болон санхүүгийн тогтвортой байдал

Үндэсний санхүүжилтийн нэгдсэн стратеги

ҮСНС-ийн хамрах хүрээ

- **Төсвийн санхүүжилт (12 бодлогын хүрээ)**
- **Хувийн хэвшлийн санхүүжилт (10 бодлогын хүрээ)**
- **Макро эдийн засгийн орчин (8 бодлогын хүрээ)**

Төсвийн санхүүжилтийн стратегиуд

ЭХ ҮҮСВЭР НЭМЭГДҮҮЛЭХ

- *Байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөг бууруулах, байгалийн нөөцийн зохистой ашиглалт, хэмнэлттэй үйлдвэрлэл, хэрэглээг дэмжсэн, орлогын тэгш бус байдлыг багасгахад чиглэсэн татварын шинэчлэлүүдийг хийж, тогтвортой хөгжлийг хангах төсвийн орон зайг нэмэгдүүлэх*
- *Тогтвортой хөгжил, байгаль орчин, уур амьсгалын зорилтуудыг хангахад зориулж Хөгжлийн санхүүгийн байгууллагууд (GCF, GEF гэх мэт)-аас авах хөнгөлөлттэй зээл, хөгжлийн албан ёсны тусламжийг нэмэгдүүлэх*
- *Эдийн засгийн бүтээмжийг нэмэгдүүлэх, тогтвортой амьжиргааг бий болгох, иргэдэд урт хугацааны үр өгөөжийг хүртээх зорилгоор Үндэсний баялагийн сан байгуулах*

ЧИГЛҮҮЛЭХ

- *Төсвийн зарлагыг дунд хугацаагаар, хөгжлийн тэргүүлэх чиглэлүүдтэй уялдуулах зорилгоор Дунд хугацааны төсөвлөлтийн хүрээг (ДХТХ) нэвтрүүлэх*
- *Жендэрийн мэдрэмжтэй, үр дүнд суурилсан төсөвлөлт нэвтрүүлэх*
- *Төсвийн хөрөнгө оруулалтыг хөгжлийн зорилтуудад чиглүүлэх*
- *Төрийн тогтвортой худалдан авах зарчмуудыг нэвтрүүлэх*
- *Хөгжлийн хамтын ажиллагааг сайжруулах, техникийн болон санхүүгийн тусламжийг хөгжлийн зорилтуудтай уялдуулах*
- *Төсвийн ТХЗ-ын ангиллын систем бий болгох*

ҮР НӨЛӨӨ

- *ТХЗ-ын гүйцэтгэлийн аудит хийж, төсвийн зарлагын менежментийг боловсронгуй болгох замаар үр ашгийг нэмэгдүүлэх*
- *ТӨҮГ олон төрийн өмчит банк санхүүгийн байгууллагуудад тогтвортой санхүүжилтийн зарчим болон тайлагналын стандарт (ESG) -уудыг нэвтрүүлэх*
- *Мөнгө угаах, терроризмтай тэмцэх үндэсний тогтолцоог боловсронгуй болгох*

Үндэсний санхүүжилтийн нэгдсэн стратеги

Хувийн хэвшлийн санхүүжилтийн стратегиуд

ЭХ ҮЦСВЭР НЭМЭГДҮҮЛЭХ

- *Шинэлэг санхүүгийн арга хэрэгсэл нэвтрүүлж, санхүүгийн болон хөрөнгийн зах зээлийг хөгжүүлэх*
- *Технологийн дэвшил ашиглан шинэлэг санхүүжилтийн хэлбэрийг дэмжих*
- *Төр, хувийн хэвшлийн түншлэлийг өргөжүүлж, хөгжлийн тэргүүлэх чиглэлүүдтэй уялдуулах*
- *Олон улсын болон дотоодын санхүүжилтийг нэмэгдүүлэх нөлөөллийн хөрөнгө оруулалтын сангууд (Impact Investment Fund) байгуулах*

ЧИГЛҮҮЛЭХ

- *Хувийн хэвшлийн ТХЗ-д чиглэсэн үйл ажиллагааг ангилах, үр нөлөөг хэмжих, тайлагнах стандарт (ТХЗ-уудын санхүүжилтийн таксономи) нэвтрүүлэх*
- *Жендэрийн мэдрэмжтэй санхүүгийн тогтолцоог нэвтрүүлэх*
- *Гадаад дотоод хандивлагчдыг нийгмийн тулгамдсан асуудал болон байгаль орчны асуудалд хувь нэмрээ оруулахыг дэмжих*

ҮР НӨЛӨӨ

- *Хувийн хэвшилд ТХЗ-ын нөлөөллийн стандарт (SDG Impact Standard)-ыг нэвтрүүлэхэд дэмжлэг үзүүлэх*
- *Байгаль орчин, нийгэм, засаглал (ESG)-ын эрсдэлийн үнэлгээ, стандартуудыг нэвтрүүлэх*
- *Байгаль орчин, нийгэм, засаглал (ESG)-ын үр дүнгийн тайлагналын стандартуудыг нэвтрүүлэх*
- *Тогтвортой санхүүгийн бүтээгдэхүүн, хөрөнгө оруулалтыг дэмжих*
- *Тогтвортой Хөрөнгийн Биржийн санаачлагыг хэрэгжүүлэх*

Уламжлалт хөрөнгө оруулалт | **Хариуцлагатай хөрөнгө оруулалт** | **Тогтвортой хөрөнгө оруулалт** | **Эерэг үр нөлөөтэй хөрөнгө оруулалт**

Макро эдийн засгийн орчинг бүрдүүлэх стратегиуд

Өрийн тогтвортой байдлыг хангах

- *Өрийн тогтвортой байдлыг хангахын зэрэгцээ тогтвортой өрийн шинэлэг арга хэрэгсэл (үүсмэл арга хэрэгсэл, тогтвортой хөгжлийн бонд, ногоон бонд гэх мэт)-үүдийг хөгжүүлэх*
- *Төрөөс хувийн хэвшлийг дэмжих, баталгаа батлан даалт гаргах замаар хөгжлийн зорилтуудыг хангахад хувийн хэвшлийн оролцоог нэмэгдүүлж, төсвийн болон өрийн дараатыг бууруулах*

Макро эдийн засаг, санхүүгийн салбарын тогтвортой байдал

- *Макро эдийн засаг, санхүүгийн салбарын тогтвортой байдал*
- *Урт хугацаатай, хямд, ногоон санхүүжилтийн эх үүсвэр татах орчин бүрдүүлэх замаар санхүүгийн салбарын тогтвортой байдлыг хангах*
- *Эдийн засгийн мөчлөг сөрсөн бодлого хэрэгжүүлэх*
- *Эдийн засгийн сэргэлт, макро болон санхүүгийн тогтвортой байдлыг дэмжих бодлого хэрэгжүүлэх*

Эдийн засгийн төрөлжилтийг дэмжих, дэд бүтэц болон тогтвортой орчин

- *Эдийн засгийн төрөлжилтийг дэмжих, дэд бүтэц болон тогтвортой орчин*
- *Тогтвортой нийлүүлэлтийн сүлжээ, түүний стандарт баталгаажуулалтын тогтолцоо, хууль эрхзүйн орчыг бүрдүүлэх*
- *Экспорт, ЖДҮ-ийг санхүүжүүлэх, баталгаа батлан даалт гаргах зэргээр эдийн засгийн төрөлжилтийг дэмжих албан институцуудыг байгуулах*

АНХААРАЛ ХАНДУУЛСАНД БАЯРЛАЛАА